



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/а 06

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 54 дүгээр тогтоол, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын халдвар аймагт бүртгэгдсэнтэй холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сумдын Онцгой комисс, шуурхай штабын үйл ажиллагааг эрчимжүүлэх, тусгаарлах байр, гэрийн ажиглалтад байгаа иргэдэд тавих хяналтыг сайжруулах, иргэдэд халдвар хамгааллын дэглэмийг сахиулах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, урьдчилан сэргийлэх, халдваргүйтгэлийг хийлгэх арга хэмжээг зохион байгуулахыг аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад, халдаргүйтгэл хийх арга хэмжээг зохион байгуулахыг Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын удирдлагуудад, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус даалгасугай.

3. Боловсролын бүх шатны сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Уранбямба)-д үүрэг болгосугай.

4. Коронавирусын халдварын батлагдсан тохиолдлын хавьтлыг илрүүлэх, тандалт судалгаа хийх арга хэмжээг шуурхай зохион байгуулж хамтарч ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210593